

**ИХ ЗОХИОЛЧ Д.НАЦАГДОРЖИЙН ХИЙСЭН  
“ГЕРМАН-МОНГОЛ ТОЛЬ БИЧИГ”-ИЙН ТУХАЙ**

Ж.Баг-Ирээдүй

Их зохиолч Дашдоржийн Нацагдоржийг 20-оод оны дундуур Герман Улсад сурч байсныг бид бүгд сайн мэднэ. Энэ тухай түүхийн болон утга зохиол судлалын ном бүтээлүүдэд дэлгэрэнгүй дурдсан байдаг. Тухайлбал дараах бүтээлүүдэд энэ талаар тодорхой бичсэн байна. Үүнд, Ц.Дамдинсүрэнгийн эрхлэн хэвлүүлсэн бүтээлд “Нацагдорж 1926 оны намар Улаанбаатараас Берлинд очиж герман хэл бичгийг нилээд оролдож байгаад, улмаар Лейпциг хотын сэтгүүлч нарын сургуульд 1929 он хүртэл суралцсан байна” (Нацагдорж, 1961: 12), проф. С.Лувсанвандан “1925 оноос Зөвлөлт Улсын Ленинград хотын Цэргийн академид суралцаж, 1926-1929 он хүртэл Герман улсын Лейпциг хотод сэтгүүлчийн сургуулийг төгсжээ” (1966: 5), эрдэмтэн Б.Содном “Нацагдорж 1926 оны намар Улаанбаатараас Берлинд очиж герман хэл бичгийг Берлинд нилээд оролдож байгаад Лайпциг хотын сэтгүүлч нарын сургуульд 1929 он хүртэл суралцсан байна. Нацагдорж тэнд герман хэл бичгийг сурснаас гадна, олон улсын эрт одоогийн түүх, гүн ухаан, Европ дахины сонгодог уран зохиол, түүний түүх, онолын асуудалтай танилцсан байна” (1966: 45), эрдэмтэн С.Лувсанвандан “Дорно дахины судлаач Эрих Хэниш прфоессорын удирдлагаар Герман улсад тухайн үед монгол судлал нэн эрчимтэй хөгжиж Монголын түүх, утга зохиолын дурсгалт бичгийг судлах, дорно дахины судлалын семинарт зориулан хэлний зүйг зохиож байсны дотор монгол хэлний зүйг онцгойлон дурдаж болно. Залуу оюутан Д.Нацагдорж туршлагатай эрдэмтэн Э.Хэнишийн дэргэд суралцсан явдал герман хэлний мэдлэгт шийдвэрлэх нөлөө үзүүлж, улмаар шинжилгээний арга барилд суралцах, орчуулгын дадлагыг эзэмшихэд зохих түлхэц болсон” (1987: 138) гэж бичжээ.

Д.Нацагдорж судлаач доктор С.Лочин “...МАХН-ын Төв Хорооноос 1926 оны 9-р сарын 11-нд Нацагдорж, Пагмадулам нарын зургаан хүнийг Герман Улсад сургуульд явуулах шийдвэр гаргажээ. Ийнхүү 1926 онд Берлинд гадаадын иргэдэд зориулсан герман хэл бичгийн сургуульд, 1927 онд Лайпциг хотноо шилжиж хятадач эрдэмтэн Э.Хэнишийн туслахаар, түүнтэй хамтран ажиллаж хувиараа буюу сайн дураараа суралцаж байв. Дээд сургуульд орох гэхэд сургууль төгссөн гэрчилгээ баримт дутагдаж Гэгээрлийн яаманд бичихэд нь ...бусад сурагчдын адилаар аль нэгэн тэнцэх сургуульд сургаваас зохино гэж 1928 оны 8 дугаар сард хариу өгч байжээ. Харин Ж.Цэвээн Нацагдорж миний дэргэд сурч байсан эрдэм боловсролтой, цаашдаа судлал шинжлэлийн ажил хийх чадвартай хүн гэж хувийн тодорхойлолт гарган явуулж байжээ. Нацагдорж 1929 оны хавар Германаас дуудагдан ирснийхээ дараа буюу мөн оны 8-р сард Герман улсад үргэлжлүүлэн суралцуулахыг гуйж НТХ, Гэгээрлийн яаманд өргөдөл бичиж байв” (2000: 7-8) гэсэн бол “Түүхэн 500 хүн” номд “Дашдоржийн Нацагдорж ...1926-27 онд Германы Берлин, Лейпциг хотуудад суралцсан. Тэрбээр Ц.Жамсрантай хамтран

Марксын *Капитал*-ын тэргүүн ботийг герман хэлнээс орчуулсан” (2014:164) гэхчлэн тус тус тэмдэглэжээ.

Д.Нацагдорж Лайпциг хотод сурч байхдаа дорно дахин судлаач, нэрт монголч эрдэмтэн д-р Эрих Хэниш (1880-1966)-ийн туслахаар ажиллаж байсан гэсэн мэдээг Д.Нацагдоржийг судалсан бараг бүх хүн дурдсан байдаг. Э.Хэниш бол 1925 онд Берлиний Их Сургуулиас Лайпцигийн Их Сургуульд шилжиж 1932 он хүртэл багшилж байсан байна. Харин Д.Нацагдорж тэнд 1926-27 онд Лайпциг хотын хэлний сургуульд герман хэл сурч байжээ. Гэвч Дорно дахин судлаачийн туслахаар ажиллах хугацаанд чухам юу хийж байсан талаар мэдээ бас харьцангуй ховор байдаг.

Энэ үед Д.Нацагдоржтой холбоотой ойр байсан хүмүүс түүний хийж байсан толь бичгийн тухай тэмдэглэсэн эсэхийг мөшгөн үзвэл эрдэмтэн Б.Ринчен абугай “Манай Улсын номын санд 1928-1929 оны орчим хийсэн хоёрын зэрэг европ монгол багашиг толь бичиг бий. Хоёулаа хэвлэгдэж чадаагүй, бичмэл эх нооргоороо байгаа нь герман-монгол хэлний толь бичгийг Ишдорж багш хийгээд Судар бичгийн хүрээлэнгийн дуун ухааны тасагт өгсний нь номын санд хадгалуулсан билээ” (1964: 96) гэсэн бол профессор З.Лонжид, О.Батсайхан нар *Монголын эх түүх-II* номд “Базарын Ишдорж ...Гэгээрлийн сайд Эрдэнэбатханы хамтаар Герман, Франц улсуудаар айлчилж, тэнд сурч байсан оюутнуудын амьдралд санаа тавьж байв. ...Тэрбээр монгол хэл бичгийн талаар нилээд хэдэн бүтээл туурвисны дотор *Герман-монгол толь бичиг* (1928)... зэрэг ном зохиолууд одоогоор мэдэгдэж байна” (2015: 11-12) хэмээн бичжээ. Харин энэ яг ямар толь бичгийн тухай бичсэнийг тодруулж чадсангүй. Харин Германы монголч эрдэмтэн Эрика Таубэ Д.Нацагдоржийн Германд сурч байх үеийн тухай “Ази, Америк, Латин Америк” сэтгүүлийн 1988 оны 5 дугаарт бичсэн өгүүлэлдээ нэлээд дэлгэрэнгүй дурдсан ба энэ өгүүлэл монгол хэлээр орчуулагдаж *Утга зохиол урлаг* сонинд хэвлэгдсэн (Тауба Эрика, 1996) билээ.

Д.Нацагдоржийн хийж байсан Герман-Монгол толь бичгийн тухай ярихад түүний Герман улсад сурч байх үеийн амьдрал анхаарал татдаг юм. Харин энэ талаар манай судлаачид бараг нэг янзын өгүүлбэр хэлдэг нь дээр эх сурвалжуудад байгаа мэдээллээс тодорхой байна. Харин Германы монголч эрдэмтэн Э.Таубэ абугайн бичсэнээр “Сурч мэдэхийн тулд өөртөө өндөр шаардлага тавьдаг, 1926 оны зун амралтаар ирсэн үедээ Цэргийн зөвлөлөөс хүлээлгэсэн үүрэг даалгаврыг идэвх зүтгэлтэй гүйцэтгэж байсан хийгээд 1921 оны Ардын хувьсгалын бүр эхнээс эх орныхоо улс төрийн амьдралд идэвхтэй оролцож байсан зэрэг нь түүнийг бусад сурагчдын хамт Герман улсад суралцуулахаар илгээх үндэс болсон хэмээн үзэх бололцоотой. Тэд 1926 оны аравдугаар сарын 17-нд Монголоос гарч Москвагаар дайран Ленинград хүрчээ. Тэндээсээ усан онгоцоор Герман хүрч, улмаар 11 дүгээр сард Берлинд ирсэн бололтой байдаг. Энэ үед хамт ирсэн залуучуудын сургалт нь туршилтын маягийн сургалт байснаас яг жинхэнэ их сургууль энэ тэрд оруулалгүй тэднийг өөр өөр хотуудаар тараасан шиг байна. Д.Нацагдорж Германд сурч байхдаа тэнд сурч байсан монгол хүүхдүүдэд зориулан *Сурагчдын бичмэл сэтгүүл* хэмээх сэтгүүлийг гаргахад биечлэн тусалдаг байсан тухай К.Н.Яцковская, Д.Цэдэв нар дурджээ. Энэ сэтгүүлд тэрбээр “Миний үе ба манай үүрэг”, “Цаг, цаг, цаг”, “Герман улсын байдлаас”, “Спорт гэж юу вэ” зэрэг өгүүллийг Элдэв-Очир гэдэг нэрээр бичдэг байсан байна. Д.Нацагдорж хоёр учир шалтгаанаар Лайпцигт ирсэн байх магадлалтай ажээ. Үүнд 1925 оноос Алма матер Липсинс Их Сургуульд Дорнод Азийн семинарыг удирдаж байсан Эрих Хэниш түүнийг Лайпцигт авчирсан байж магад. Тэрбээр монгол хэл, утга зохиол судалдаг байсан болохоор түүний судалгаанд Д.Нацагдорж шимтэн татагдаж, энэ эрдэмтэнтэй ойртон ажиллах хүсэлдээ хөтлөгдөн ирсэн байх үндэстэй ажээ. Д.Нацагдорж Лайпцигт шилжин суухад Сергей Вольф нөлөөлсөн болохыг бид мэднэ. Учир нь тэрбээр Д.Нацагдоржоор монгол хэл заалгаж,

хариуд нь герман хэл зааж байсны дээр монгол сурагчдын талаар их санаа тавьдаг хүн байсан ажээ. Сергей Вольф Э.Хэништ танилцуулснаар Лейпцигт өөрийн дэргэд авчирсан байна.

Германы нэрт монголч эрдэмтэн Э.Хэниш бол "1880 оны 8 дугаар сарын 27-нд Берлин хотноо сурвалжит гэр бүлд төрж, гимнази төгсөн 1899 оноос Берлиний Их Сургуульд оюутан болж хятад, манж, монгол хэл суралцан 23 насандаа Саган Цэцэний *Эрдэнийн товч* хэмээх сурвалж бичгийн судалгаагаар эрдмийн зэрэг хамгаалсан билээ. Их сургууль төгсөөд Хятадын Цэргийн Их Сургуульд герман хэлний багшаар ажиллаж байхдаа хятад хэл судлалаар чамбай суралцжээ. 1911 оноос Берлиний Угсаатны судлалын музейд судлаач, 1912 оноос Берлиний Их Сургуульд багш, 1925 оноос Лайпцигийн Их Сургуульд Хятад судлалын тэнхимийн эрхлэгч, 1932 оноос Берлиний Их Сургуулийн Хятад судлалын тэнхимийн эрхлэгчээр тус тус ажилласан байна. Тэрбээр 1966 онд 86 насандаа таалал төгсчээ" (2017: 174-175) гэж академич Д.Төмөртоогоо багш бичжээ. Харин Э.Хэниш Лайпцигт байхдаа тэр үед монгол судлалаас илүү хятад судлалыг сонирхон мөн германд сурч байсан хятадуудтай холбоо тогтоож, өөрийн семинартаа хятадын судлаачдыг оролцуулж, сургадаг байсан байна. Тэр үед хараахан Монголд ирээгүй, монгол хэлний мэдлэг нь ч тун гүехэн байжээ. Харин Д.Нацагдоржтой ажиллаж эхлэх үеэс монгол судлалын ажлыг эрчимжүүлэн монгол дөрвөлжин бичгээрх сурвалжийг судалж байсан аж. Мөн монгол хэлний хичээлийг идэвхжүүлэн ярианы хэл заалгах санаачлага гарган Германд анхны монгол судлалыг хөгжүүлэх суурийг тавьсан байна. Дорнод Азийн семинарын 1927 оны зун цагийн хичээлийн хуваарьт "Монгол ярианы хэл" гэсэн хичээл нэмэгдсэн нь Д.Нацагдоржийн Лайпцигт байх хугацаатай таарч байдаг юм. Мөн энэ үеэр Э.Хэнишийн *Монгол хэлний дүрэм, Хятад, манж, монгол хэлний бурхан шашны олон хэлний дурсгалт бичиг, Монгол хэлний унших бичиг, Бичгийн болон аман зохиол дахь монгол ардын үлгэрүүд* зэрэг бүтээл гарсан нь цаг хугацааны хувьд мөн Д.Нацагдорж Лайпцигт ирснээс хойш болов уу гэдэг нь сонирхолтой байна. Харин Д.Нацагдорж яг Лайпцигт байсан тухай барим тавим баримт байдаггүй боловч түүнтэй хамт сурч байсан Лувсаннамжил, Рэгзэн зэрэг хүний дурсамж ярианд Лайпцигт байсан тухай, бие биенийхээрээ зочилж орж гардаг байсан тухай дурдагддаг юм.

"Э.Хэниш бол мэргэжлийн чиглэлээр Монголын эрдэмтэдтэй анх удаа харилцаа холбоо тогтоосон эрдэмтэн бөгөөд 1928 оны зун БНМАУ-д хийх аяллынхаа талаар гүн ухааны факультетад гаргасан өргөдөлдөө уг аялал нь *хэл, ном судар, угсаатны зүйн* судалгаа хийх зорилготой болох тухай дурдсан байх агаад энэхүү аялалд нягт нямбай бэлтгэхэд хэн нэгэн тусалсан байх магадлалтай энэ нь нөхөр Д.Нацагдорж мөн байх" гэж Э.Таубэ гуай үзжээ.

Проф. Э.Хэниш анх удаа Монголд ирээд өөрийнхөө төлөвлөсөн хугацаанаасаа илүү суух, ажиллах шаардлагатай болсон нь сургуулийнхаа захиргаанд амралтаа олгож өгөхийг хүссэн өргөдөл гаргаж өгснөөс тодорхой байна. Ингээд тэрбээр нутагтаа ирсний дараа *Монголчуудын түүх угсаатны зүй, Монголын орон судлал* зэрэг хичээлийг зааж эхэлсэн төдийгүй *Монголын нууц товчоон*-ы хэвлэмэл эхийг олж очин хятад хувилбарыг 1931 онд хэвлүүлжээ. Мөн 1930 оны 11-р сарын 8 нд нэг сэдэвт зохиолоо бичиж Саксоны академид өргөн барьсан нь Д.Нацагдоржийн Лайпцигт байх үетэй тохирч байна. Энэ бүхнээс дүгнээд Д.Нацагдорж бол Германы Монгол судлалын төвд ирж ажилласан анхны монгол хүн даруй мөн гэж тодорхойлжээ.

Гадаадын болон дотоодын Нацагдорж судлаач нар Б.Ринчен гуайг эс оруулбал академич Ц.Дамдинсүрэн, Б.Содном, С.Лувсанвандан, С.Лочин, Д.Цэдэв, К.Н.Яцковская, Э.Таубэ нар Э.Хэниш, Д.Нацагдорж нарын хийж байсан Герман-Монгол толь бичгийн талаар нэг нь ч дурдаагүй бөгөөд харин монголч эрдэмтэн Э.Таубэ "...харин Нацагдоржийн оруулсан хувь нэмэр хэр их байсан, дээрх судалгаа боловсруулалтын ажлын чухам аль хэсгийг нь гүйцэтгэсэн зэргийг тодорхойлох өөр баримт сэлт Лайпцигаас эс олдоно" гэжээ.

Д.Нацагдоржтой холбоотой бичиг баримт, архивын материал олдохгүй байгаа шалтгааныг тэд тодруулахдаа түүний оршин сууж байсан бүртгэл хаяг маш тодорхойгүй, 1927 оны хавраас 1929 оны гуравдугаар сар хүртэл Лайпцигт амьдрахдаа түүний зохиолд гарч байгаагаар барагцаалбал Видебахплац буюу Видебарын талбай хавьцаа байсан болов уу гэж үздэг байна. Дорнод Азийн Семинарын төвд судлаач, доцент Фридрих Веллер гэдэг хүний дурсамж яриагаар бол 1937 онд Их сургуулийн Нацистын талыг баримталсан багшлах бүрэлдэхүүний зүгээс түүний эсрэг хүчтэй шахалт үзүүлж, ноцтой халдлага хийжээ. Тэрбээр еврей гаралтай эрдэмтэн, хэвлэлийн газрын эзэн Авиа Метор Бруно Шиндлерийг талархан дэмжиж, хамтран ажилладаг байсан ба Шиндлер 1935 онд гадаадад дүрвэн гарчээ. Тэд түүний хувийн тэмдэглэл, бичиг баримт, өнгөрсөн үед холбогдох бүх зүйлийг нь галдан шатаасан байна. Ийнхүү Д.Нацагдоржийн тухай болон түүний Лайпцигт байсан үед холбогдох баримт тэмдэглэл үрэгдсэн гэж үздэг юм байна гэж Э.Таубэ бичсэн ба Э.Хэнишийн архиваас маш өчүүхэн зүйл үзсэн бөгөөд бүгдийг үзэж амжаагүй гэж дурдсан байна. Харин Д.Нацагдоржийн бөөгийн дуудлагын 200 гаруй мөр шүлгийг герман хэлний хадмал орчуулга болон бусад зүйлийг багтаасан тэмдэглэлийн дэвтрийг академич П.Хорлоо агсан олсон тухай дурдсан байдаг боловч чухам хаана хадгалж байгааг хэн ч үл мэднэ.

Миний бие 2015 оноос Боннын Их Сургуулийн Монгол-Төвөд судлалын тэнхимийн (Зураг №1) урилгаар тус тэнхимд гурван он дамнан монгол судлалын зочин профессороор ажиллалаа. Энэ үед манай монгол судлалын салбарын байрлаж байгаа хуучин байрыг удаан хугацаатай их засварт оруулах болж бид орчин үеийн өөр тохилог байранд нүүхээр нүүдэл суудалдаа бэлдэж, тус тэнхимийн номын санг (зураг №2) нүүлгэж байх үед тус номын сангийн ажилтан Карл Д.Нацагдоржийн хийж байсан *ГЕРМАН-МОНГОЛ ТОЛЬ БИЧИГ*-ийн хоёр дэвтэр гар бичмэл эх (оригиналь) олж надад үзүүлсэн юм.

Уг толь бичгийн гар бичмэлийн байдлыг та бүхэн зургуудаас (Зураг №3-6) үзэж сонирхох буй за. Энэ гар бичмэл нь Боннын Их Сургуулийн Монгол-Төвд судлалын тэнхимийн номын санд Eb 49 I, Eb 49 II кодтойгоор хадгалагдаж буй. Харин биднээс өмнө ямар нэгэн хэмжээгээр хэн нэгэн мэдэж байсан, энд тэнд дурдсан зүйл одоогоор олдсонгүй.

Хамгийн түрүүнд Д.Нацагдоржийнх мөн эсэхийг тодруулах ёстой бөгөөд Д.Нацагдоржийн гарын үсэг нь гарцаагүй мөн болохыг бусад зохиолын гар бичмэлийн бичгийн тигтэй харьцуулснаар мэдэж болно. Мөн дотор нүүрийн эхний хуудсанд Д.Нацагдорж И.Я.Шмидтийн 1800-аад оны сүүлээр Петербург хотноо хэвлүүлсэн Монгол-Орос-Герман толь бичгийн толгой үгийг үндэслэн хийсэн болохоо Германд 1941 оноос өмнө бичиж байсан бичмэл цагаан толгойн үсгээр тодорхой сайхан бичсэн байна.

Энэ толь бичиг яагаад энэ номын санд хадгалагдаж байгаа талаар таамаглахад энэхүү номын санг үүсгэн байгуулсан нэрт монголч эрдэмтэн Вальтер Хайссиг гуай Д.Нацагдоржийн шавилсан Эрих Хэнишийн шавь, түүнтэй эрдэм номын дотно харилцаатай байсан бөгөөд сүүлд түүнд өгснийг профессор тус номын санд хадгалсан байж магадгүй гэж тааварлаж байна.

Энэ бол Д.Нацагдорж судлал, мөн Герман-Монгол толь бичгийн судлалд шинэ олдвор байж магадгүй. Тус толь бичгийн эхийг чухам хэрхэн яаж энд ирснийг эрдэмтэн судлаач нараас асууж сураглах, тодруулах, цаашид хэрхэн эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулах талаар манай багш нар хэлэлцэж байгааг дашрамд дурдъя.

Энэхүү толь бичиг нь хоёр дэвтэр бөгөөд тус бүр 150 гаруй хуудастай нийт 302 хуудас юм. Хэмжээ нь DN A4 буюу 210 мм x 297 мм болой. Тус хоёр дэвтрийн эхний ботийн гадна талд **Haenisch Ostasiatisches Seminar der Universität Leipzig, A bis K** буюу монголоор орчуулбал *Хэниш, Лайпцигийн их сургууль, Дорно дахины семинар буюу тэнхим, А-К үсэг хүртэл* гэж

бичжээ. Мөн толь бичгийн эхний ботийн эхний хуудсан дээр **Geschrieben von Natsok Dorji unter Aufsicht von E Haenisch, Ostas. Seminar d. Univ. Leipzig 1927** хэмээн гараар, **Alphabetisches Verzeichnis der deutschen Wörter und Ausdrücke** гэж бичгийн машинаар, **ca. 8900 Wörter** гэж харандаагаар, **aus I.J.Schmidt's deutsch. Mongolischen Wb. Petersbg 1835** гэж үзгээр бичсэнийг орчуулбал *Хениш багшийн удирдлагадор Нацагдоржийн бичсэн нь, Лайпцигийн Их Сургуулийн Дорно дахины семинар буюу тэнхим 1927 он, герман үг хэллэг нэр томъёоны цагаан толгойн бүртгэл ойролцоогоор 8900 үг хэллэг, Шмидтийн Герман-Монгол толь бичгээс Петербург хот 1835 он* гэжээ. Ингэж герман хэлээр бичихдээ 1911 оноос 1941 он хүртэл Германд хэрэглэж байсан Sütterlinschrift гэдэг бичмэл үсгээр бичсэн байх бөгөөд үүнийг одоогийн герман хэлэнд буулган орчуулсан болно.

Дүгнэх нь, ийнхүү энэхүү толийн эхний ботийн нэгдүгээр нүүрэнд герман хэлээр Э.Хэнишийн бичсэн тайлбарт байгаагаар Д.Нацагдорж түүний удирдлагаар И.Я.Шмидтийн хийсэн Монгол-Орос-Герман толь бичгийн герман үгийн санд түшиглэн толгой үг хийж түүнийг монгол хэлээр монгол бичгээр орчуулан бичиж хийсэн нь тодорхой байна.

Энэ толь бичгийн зарим үгийг өнөөгийн орчин цагийн Герман-Монгол толь (Hans-Peter Vietze, 2012) бичгийн толгой үгтэй харьцуулан үзвэл бараг бүрэн тохирох бөгөөд харин ч зарим ойролцоо үгийн утгын оноолт илүү оновчтой болсон шиг байна. Тиймээс цаашид уг толь бичгийн дотор агуулгыг бусад толь бичигтэй харгуулан бүрэн шинжлэн судлах шаардлагатай байна.

Толь бичгийг бичсэн монгол бичгийн гарын тиг нь Д.Нацагдоржийн гарын тиг мөн болохыг түүний монгол бичгээр бичсэн бусад зохиол болон Нацагдорж судлаач нарын танилтаар баталгаажуулж болж байна. Миний бие Монголын Нацагдорж судлаач эрдэмтэн Ч.Жачин, Л.Дашням нарт үзүүлэхэд тэд яах аргагүй л Д.Нацагдоржийн гар бичмэл мөн байна даа хэмээн дуу алдацгааж байлаа.

Ийнхүү профессор Э.Хэнишийн удирдлага дор хийсэн толь бичиг болох нь түүний гар бичмэлээр баталгаажсан, дээр нь Нацагдоржийн өөрийнх нь монгол бичгийн гарын тиг мөн болох нь баталгаатай тул 1927 онд хорь гаруйхан настай байсан залуу Д.Нацагдорж 9000 орчим үгтэй Герман-Монгол толь бичиг зохиох буюу толь бичгийн эрдэм шинжилгээний ажил хийж байсан нь тодорхой болж байна.

Энэ дашрамд тэмдэглэхэд Д.Нацагдоржид хүн бэлэглэсэн, түүнд хадгалагдаж байсан өөр хүмүүсийн хийсэн толь бичгийг Д.Нацагдорж хийсэн мэтээр бичиж дурдсан зүйл, ойлголт судлаачдын дунд түгээмэл байдаг нь энэ толь бичгийн талаар судалгаа хийх явцад анзаарагдлаа. Судалгааны явцад хэд хэдэн хүн ийм толь бичиг Монголд байгаа гэж хэлсэн боловч үүнийг мөшгөн хөөвөл дээрх мэт толь бичиг байсныг дурдахгүй өнгөрч болохгүй байх.

Цаашид энэ бүтээлийг хоёр хэлний орчуулгын талаас, герман-монгол үгийн оноолтын талаас, тухайн үгийн утга, үүргийн талаас нарийн судалж үзэх зайлшгүй шаардлагатай нь мэдээж бөгөөд боломжтой бол уг толь бичгийг судалгааны эргэлтэнд оруулж хэвлэх буюу дижитал болгох боломжийг эрэлхийлж байна.

Номзүй


- Алимаа С., Лувсан Г. *Германы монголч эрдэмтдийн товч намтар, бүтээлийн жагсаалт* [Kutzbiographie und Bibliographie von Deutschen Mongolisten]. Уб., 2002.
- Балдан Л. *Дашидоржийн Нацагдоржийн амьдралын мөчлөг*. Утга зохиол сонин. 1997.11. №21-22. *Герман-Монгол өврийн толь бичиг*. Pons, Монсудар, Уб., 2015.
- Дашням Г. Д. *Нацагдоржийн Лейпцигийн жилүүд хэмээх тодруулах зүйлс*. Сэтгүүлч сэтгүүл. Уб., 1989. №38, х.17-19.
- Ишдорж Б. *Монгол улсын хураангуй түүх*. Эрх. З.Лонжид нар. Уб., 2015.
- Ловор Г. Д. *Нацагдорж судлалын ном зүй*. Монгол судлалын чуулган. Боть VII, №2 (38). Уб., 2007, х.206-219.
- Лочин С. *Дашидоржийн Нацагдорж*. Хорьдугаар зууны монгол зохиолчид-1. Уб., 2000.
- Лувсанвандан С. *Дашидоржийн Нацагдорж*. Уб., 1966.
- Нацагдорж Д. *Зохиолууд*. Ред. Ц.Дамдинсүрэн. Уб., 1961.
- Нацагдорж Д. *Бүрэн зохиол-2*. Хэв. бэлд. Д.Цэдэв. Уб., 2004.
- Очир А., Дашням Г. Д. *Нацагдоржийн намтрын зарим хуудсыг нэмж тодруулах нь*. Утга зохиол урлаг сонин. Уб., 1985.07.11. №28 (1502).
- Очир А. *Тайлбар толь зохиолцож байсан нь*. Утга зохиол урлаг. 1986.10.31. №44 (1570).
- Пүрэвжав Э. *Монгол хэл бичгийн судлал-11*. Уб., 2008, х.47-72.
- Таубэ Эрика. *Нацагдоржийн Лейпцигт байсан үеийн ул мөрийг мөшигин судалсан минь*. Ням гариг. 1996.9.15, №37.
- Төмөртоогоо Д. *Монгол хэлишнжлэлийн судалгааны түүхээс*. Уб., 2017, х.174-175.
- Түүхэн 500 хүн: Дэлхий дахинд ба Монголд*. Нерко, Уб., 2014.
- Цэнд Д. *Дашидоржийн Нацагдоржийн амьдрал уран бүтээл*. Багш сэтгүүл. №3-4. Уб., 1956.
- Цэдэв Д. *Их зохиолчийн намтрын хуудаснаас*. Утга зохиол урлаг сонин. 1982.11.19, №17 (1365).
- Эгиймаа Ц. *Дашидоржийн Нацагдоржийн толь бичиг*. Нүүдэлчдийн өв судлал. Т-ХVII. Уб., 2016, х.165-169.
- Эрдэнэбаатар Б. *Бид Лейпцагт хамт байсан* (Лувсаннамжилтай хийсэн ярилцлага). Залуучуудын үнэн. Уб., 1986.11.16. №127.
- Hans-Peter Vietze. *Wörterbuch Deutsch-Mongolisch*. Dao-Verlag, Berlin, 2012.




Зураг №1. Боннын Их Сургуулийн Монгол-Төвд судлалын салбарын байр



Зураг №2. Боннын Их Сургуулийн Монгол-Төвд судлалын тэнхимийн номын сан




Зураг №3. Д.Нацагдоржийн хийсэн Герман-Монгол хоёр боть толь бичгийн эх




Зураг №4. Уг толь бичгийн эхний хуудсууд





Зураг №5. Герман-Монгол толь бичиг-ийн нэгдүгээр ботийн эхний хуудас



Зураг №6. Эхний ботийн 155 дахь хуудас